

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/2/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: <a href="#">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Энхдалай Утас:51-260512 Цахим хаяг: <a href="#">enkhdalaid@audit.gov.mn</a> Аудитор: Ж.Мөнхбилгүүн Утас: 51-261628 Цахим хаяг: <a href="#">munkhbilguunj@audit.gov.mn</a> Аккаунт траст аудит ХХК-ийн захирал: П.Наранцэцэг Цахим хаяг: <a href="#">acctrust.audit@gmail.com</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	12
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин.....	12
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	12
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1. Төвийн санхүүгийн тайланд хийсэн аудит .....	18
5.2 Харьяа салбаруудад хийсэн аудит.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	23

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗЗАН	Авто замын засвар арчлалтын нэгтгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН  
НЭГТГЭЛ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Б.НАРАНБАТ ТАНАА

2026.03.16 № 06/721  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 33,257.1 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант оны орлогын төлөвлөгөө 21,736.3 сая төгрөгөөр тасарсан, Улсын төсвийн Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын зардлын санхүүжилттэй уялдуулан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний төлөвлөгөөг тодотгон батлуулаагүй;
- Нийт салбаруудын авлагын дансанд бүртгэлтэй 2-оос дээш жилийн насжилттай 65 харилцагчаас авах 1,736.0 сая төгрөгийн авлага, 53 харилцагчид өгөх 1,179.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй;
- Тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны гэрээ байгуулах зөвлөмжийн дүнг 408.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж гэрээг байгуулсан;
- Нээлттэй тендер шалгаруулалтаар шалгарсан 6 аж ахуйн нэгжээс гэрээний үнийн дүнгийн 20.0 хувиас илүү 137.3 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн ;
- Татварын цахим системд 57 харилцагчийн 428.3 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний и баримт бүртгэгдээгүй;

Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3, 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, 40 дүгээр зүйлийн 40.2, 40.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 71 дүгээр зүйлийн 8, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК нь Монгол улсын нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх Олон улс, улсын чанартай 52 чиглэлийн 9,106.29 км авто зам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг гүйцэтгэж, замын хөдөлгөөний бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2023 оны Авто замын засвар арчлалтын компаниудыг өөрчлөн зохион байгуулах зарим арга хэмжээний тухай 220 дугаар тогтоолын дагуу "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК байгуулагдаж, авто замын засвар арчлалтын ажил эрхэлдэг 20 компанид татварын шалгалт хийлгэн, компаниудыг татан буулгаж 2025 оны 5 сард салбар нэгжийн зохион байгуулалтад оруулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 34,632.6 сая төгрөгийн Улсын чанартай авто зам, замын байгууламжийн, 18,321.4 сая төгрөгийн орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн, цаг үеийн онцгой ажил 558.6 сая төгрөг, нийт 53,512.6 сая төгрөгийн засвар, арчлалтын ажлыг гүйцэтгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус ТӨХК нь Зам засварын ажилд эрсдэлийн үнэлгээ хийж, 15 стандарт журмыг мөрдүүлж, бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын иж бүрэн хэрэгслээр бүрэн ханган ажилласнаар осол эндэгдэлгүй ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.НАРАНЧИМЭГ*



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,800,335,177.54	4,485,469,071.43
1.1.2	Дансны авлага	4,041,724,087.70	8,545,197,673.53
	Салбар хоорондын авлага	370,311,592.18	758,208,136.07
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	96,187,566.43	105,783,644.75
1.1.4	Татаас санхүүжилтийн авлага	255,489,121.00	-
1.1.5	Бусад богино хугацаат авлага	92,696,026.50	5,803,782,764.63
1.1.6	Бараа материал	5,775,225,298.71	8,970,117,216.82
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	94,458,035.09	43,586,363.64
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	349,205,431.12	598,209,124.12
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>13,875,632,336.27</b>	<b>29,310,353,994.99</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	19,751,036,594.66	17,046,038,566.52
1.2.2	Биет бус хөрөнгө	6,338,796,176.41	6,354,768,255.04
1.2.20	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>26,089,832,771.07</b>	<b>23,400,806,821.56</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>39,965,465,107.34</b>	<b>52,711,160,816.55</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	4,689,626,175.49	17,320,621,674.49
2.1.1.2	Цалингийн өглөг	21,148,691.82	935,544,145.24
2.1.1.3	Татварын өр	3,864,591,060.76	5,240,341,370.81
2.1.1.4	НДШ-ийн өглөг	959,063,934.35	1,513,534,262.18
2.1.1.5	Богино хугацаат зээл	290,320,458.74	29,388,447.91
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	486,145.00	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	17,439,000.00	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		700,485,776.86
2.1.1.20	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>9,842,675,466.16</b>	<b>25,739,915,677.49</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	3,417,164,528.00	
2.1.2.20	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,417,164,528.00</b>	<b>-</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>13,259,839,994.16</b>	<b>25,739,915,677.49</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Төрийн өмч	22,188,285,369.10	23,494,425,143.10
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	31,497,846.00	31,497,846.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,338,884,455.23	7,338,884,455.23
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	7,626,272,874.68	9,737,297,628.68
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(10,479,315,431.83)	(13,630,859,933.95)
2.3.20	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>26,705,625,113.18</b>	<b>26,971,245,139.06</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>39,965,465,107.34</b>	<b>52,711,160,816.55</b>

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого ( цэвэр )	57,597,648,969.41	53,512,623,137.59
3	Борлуулалтын өртөг	49,688,290,343.45	42,891,113,978.89
<b>4</b>	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>7,909,358,625.96</b>	<b>10,621,509,158.70</b>
5	Түрээсийн орлого	-	32,581,902.00
6	Хүүгийн орлого	11,261,845.49	112,310,274.25
8	Үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил үйлчилгээний орлого	329,347,312.35	809,087,063.00
9	Бусад орлого	85,773,730.91	16,046,000.00
11	Ерөнхий ба удирдлагын зардал	9,988,182,718.00	11,506,331,333.55
12	Санхүүгийн зардал	20,783,907.87	402,218,031.46
13	Бусад зардал	1,487,051,490.35	1,185,908,131.88
15	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )		700,000.00
<b>19</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>(3,160,276,601.51)</b>	<b>(1,502,223,098.94)</b>
20	Орлогын татварын зардал	55,436,595.95	32,598,827.75
<b>21</b>	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(3,215,713,197.46)</b>	<b>(1,534,821,926.69)</b>
<b>23</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>(3,215,713,197.46)</b>	<b>(1,534,821,926.69)</b>
<b>28</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(3,215,713,197.46)</b>	<b>(1,534,821,926.69)</b>

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>22,188,285,369.10</b>	<b>31,497,846.00</b>	<b>7,338,884,455.23</b>	<b>7,626,272,874.68</b>	<b>(7,263,602,234.37)</b>	<b>29,921,338,310.64</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>22,188,285,369.10</b>	<b>31,497,846.00</b>	<b>7,338,884,455.23</b>	<b>7,626,272,874.68</b>	<b>(7,263,602,234.37)</b>	<b>29,921,338,310.64</b>
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )					(3,215,713,197.46)	<b>(3,215,713,197.46)</b>
<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>22,188,285,369.10</b>	<b>31,497,846.00</b>	<b>7,338,884,455.23</b>	<b>7,626,272,874.68</b>	<b>(10,479,315,431.83)</b>	<b>26,705,625,113.18</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					(1,616,722,575.43)	<b>(1,616,722,575.43)</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>22,188,285,369.10</b>	<b>31,497,846.00</b>	<b>7,338,884,455.23</b>	<b>7,626,272,874.68</b>	<b>(12,096,038,007.26)</b>	<b>25,088,902,537.75</b>
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )					(1,534,821,926.69)	<b>(1,534,821,926.69)</b>
Өмчид гарсан өөрчлөлт	1,306,139,774.00			2,111,024,754.00		<b>3,417,164,528.00</b>
<b>2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>23,494,425,143.10</b>	<b>31,497,846.00</b>	<b>7,338,884,455.23</b>	<b>9,737,297,628.68</b>	<b>(13,630,859,933.95)</b>	<b>26,971,245,139.06</b>

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>63,272,270,318.81</b>	<b>68,783,582,723.35</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	62,217,810,570.18	67,871,667,205.29
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		22,903.21
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	128,971.00	2,800,983.27
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,054,330,777.63	909,091,631.58
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>62,761,700,428.99</b>	<b>66,405,424,679.56</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	22,792,137,482.11	35,230,018,580.30
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,555,903,617.52	6,739,196,987.62
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	18,536,946,242.61	8,717,695,667.20
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	394,844,936.00	1,856,651,159.96
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,256,104,309.94	8,556,590,663.38
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	223,624,246.39	103,083,605.07
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,382,784,196.11	1,125,068,347.42
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	42,294,724.76	43,310,138.76
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,577,060,673.55	4,033,809,529.85
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>510,569,889.82</b>	<b>2,378,158,043.79</b>
<b>2.00</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>33,849,829.62</b>	<b>105,828,198.55</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	24,379,100.00	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	3,300,000.00	
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	115,500.00	
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	6,055,229.62	105,828,198.55
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>408,589,639.80</b>	<b>463,468,090.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	408,589,639.80	413,468,090.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		50,000,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(374,739,810.18)</b>	<b>(357,639,891.45)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>1,876,000,000.00</b>	<b>3,268,250,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,876,000,000.00	3,268,250,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>1,487,136,367.00</b>	<b>3,603,634,258.45</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	1,432,841,602.00	3,603,148,113.45
3.2.4	Төлсөн ногдол ашиг	54,294,765.00	486,145.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>388,863,633.00</b>	<b>(335,384,258.45)</b>
5.00	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<b>524,693,712.64</b>	<b>1,685,133,893.89</b>
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,275,641,464.90	2,800,335,177.54
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,800,335,177.54	4,485,469,071.43

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>			<b>58,024,031.9</b>	<b>76,219,646.0</b>	<b>54,483,348.4</b>	<b>(3,540,683.5)</b>	<b>93.9</b>	<b>(21,736,297.6)</b>	<b>71.48</b>
1	Тендерийн буцаалт	м.төг	-		1,935.0	1,935.0		1,935.0	
	Улсын чанартай автозамын засварын орлого	м.төг	57,597,649.0	41,090,800.0	34,632,585.6	(22,965,063.4)	60.1	(6,458,214.4)	84.3
	Орон нутгийн чанартай автозамын засварын орлого	м.төг		35,128,846.0	18,321,475.1	18,321,475.1		(16,807,370.9)	52.2
	Үйл ажиллагааны бусад орлого	м.төг	-	-	558,562.5	558,562.5		558,562.5	
	Түрээсийн орлого	м.төг	-	-	32,581.9	32,581.9		32,581.9	
	Хүүний орлого	м.төг	11,261.8		112,310.3	101,048.4	997.3	112,310.3	
	Бусад орлого	м.төг	329,347.3		-	(329,347.3)	-	-	
	Үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил үйлчилгээний орлого	м.төг	85,773.7		823,198.1	737,424.3	959.7	823,198.1	
Бусад үйл ажиллагааны бус орлого	м.төг			700.0	700.0		700.0		
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>58,024,031.9</b>	<b>76,219,646.0</b>	<b>54,483,348.4</b>	<b>(3,540,683.5)</b>	<b>93.9</b>	<b>(21,736,297.6)</b>	<b>71.5</b>
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>61,239,745.1</b>	<b>75,887,189.0</b>	<b>55,985,571.5</b>	<b>(5,254,173.6)</b>	<b>91.4</b>	<b>(19,901,617.5)</b>	<b>73.8</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	8,802,343.4	10,077,846.0	11,506,331.3	2,703,987.9	130.7	1,428,485.3	114.2
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>(3,215,713.2)</b>	<b>332,457.0</b>	<b>(1,502,223.1)</b>	1,713,490.1	46.7	(1,834,680.1)	(451.9)
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>(3,215,713.2)</b>	<b>332,457.0</b>	<b>(1,534,821.9)</b>	1,680,891.3	47.7	(1,867,278.9)	(461.7)
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>6,874,513.9</b>	<b>10,209,920.3</b>	<b>8,936,636.0</b>	2,062,122.1	130.0	(1,273,284.3)	87.5
	а/ Орлогын татварт	м.төг	55,436.6	33,246.0	32,598.8	(112,379.5)	22.5	(647.2)	98.1
	б/ НӨТ	м.төг	1,898,693.2	3,691,005.0	55,727.0	(1,842,966.3)	2.9	(3,635,278.0)	1.5
	в/ НДШ	м.төг	3,775,939.4	3,705,309.0	6,660,036.3	2,884,096.9	176.4	2,954,727.3	179.7
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	815,036.9	2,252,786.0	1,920,629.1	1,105,592.2	235.6	(332,156.9)	85.3
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	41,187.1	48,523.0	62,840.8	21,653.7	152.6	14,317.8	129.5
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	27,937.6	171,139.3	61,892.1	33,954.6	221.5	(109,247.2)	36.2
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	253,326.0	307,912.0	142,911.9	(110,414.1)	56.4	(165,000.1)	46.4
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	6,957.1	36,022.0	-	(6,957.1)	-	(36,022.0)	-

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

8	Нийт ажиллагсдын тоо	хүн	776.0	799.0	729.0	(47.0)	93.9	(70.0)	91.2
9	Нийт цалингийн сан	м.төг	15,573,689.6	25,455,207.0	21,246,578.0	5,672,888.4	136.4	(4,208,629.0)	83.5
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,672.4	2,547.0	2,428.7	756.3	145.2	(118.3)	95.4
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.1	1.0	1.0	(0.0)	97.4	0.0	103.2
12	Хөрөнгө оруулалт	м.төг	686,946.8	8,602,909.0	1,008,458.6	321,511.8	146.8	(7,594,450.4)	11.7
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>4,856,408.4</b>	<b>1,940,292.0</b>	<b>15,212,972.2</b>	<b>10,356,563.8</b>	<b>313.3</b>	<b>13,272,680.2</b>	<b>784.1</b>
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>13,259,840.5</b>	<b>9,616,477.0</b>	<b>25,739,915.7</b>	<b>12,480,075.2</b>	<b>261.5</b>	<b>16,123,438.7</b>	<b>267.7</b>
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	9,842,675.5	9,616,477.0	25,739,915.7	15,897,240.2	261.5	16,123,438.7	267.7
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	3,417,164.5	-	-	(3,417,164.5)	-	-	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн дүрэмд “Компанийн үндсэн зорилт нь олон улс, улсын чанартай болон орон нутгийн чанартай авто зам эзэмшигчтэй авто зам, замын байгууламжийн ашиглалтын байнгын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэн ажиллаж, хувьцаа эзэмшигчдэд ашиг хүртээхэд оршино.” гэж тодорхойлсон байна

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК нь 100 хувь төрийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон “Эрчист Монгол” ТӨХХК байна. Компани нь орон нутагт салбар, нэгжтэй бөгөөд салбар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Компани нь дараах үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Авто замын ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах;
- Хариуцсан замд тогтоосон журмын дагуу үзлэг хийж, арчлалт, засварын ажлыг тогтмол гүйцэтгэх;
- Хариуцсан авто зам, замын байгууламжийн эвдрэл гэмтлийн талаарх мэдээллийг тухай бүр авч, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;
- Хариуцсан авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн санг хөтөлж, нэгдсэн бүртгэлд оруулах ажлыг тухай бүр зохион байгуулах;
- Хариуцсан авто замын зурвас болон хяналт тавих зурвас газрыг хамгаалах ажлыг зохион байгуулж, үүнтэй холбоотой эрх бүхий байгууллагаас авах арга хэмжээний саналыг боловсруулан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
- Хариуцсан авто зам, замын байгууламжийн өмчлөгч болон эзэмшигчийг авто зам, замын байгууламжийн ашиглалтын талаарх мэдээллээр хангах;
- Гамшиг, ослын улмаас хариуцсан авто замд эвдрэл, гэмтэл гарч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саатсан үед олон нийтэд мэдээлж, саадыг арилгах арга хэмжээг шуурхай авах;
- Хариуцсан авто замаар зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү овор даацтай болон тусгай хамгаалалтгүй гинжит дугуйтай тээврийн хэрэгсэл зорчихоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулж, үүнтэй холбоотой эрх бүхий байгууллагаас авах арга хэмжээний саналыг боловсруулан, шийдвэрлүүлэх арга хэмжээг авах;
- Хариуцсан авто замын хөдөлгөөний эрчмийн тооллогыг зохих журмын дагуу зохион байгуулах.

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК нь үйл ажиллагаандаа Авто замын тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,745,695.7 мянган төгрөгөөр буюу 31.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,800,335.2	4,485,469.1	1,685,133.9
Авлага	4,950,866.4	15,256,558.6	10,305,692.2
Бараа материал	5,775,225.3	8,970,117.2	3,194,891.9
Бусад эргэлтийн хөрөнгө	349,205.4	598,209.1	249,003.7
Үндсэн хөрөнгө	26,089,832.8	23,400,806.8	(2,689,026.0)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>39,965,465.1</b>	<b>52,711,160.8</b>	<b>12,745,695.7</b>
Өр төлбөр	13,259,840.0	25,739,915.7	12,480,075.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	26,705,625.1	26,971,245.1	265,620.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>39,965,465.1</b>	<b>52,711,160.8</b>	12,745,695.7

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,485.5 сая төгрөг болж 1,685.1 сая төгрөгөөр өссөн нь оны эцэст Улсын чанартай зам засвар арчлалтын санхүүжилт орж ирсэн;
- Авлага дансны үлдэгдэл 15,256.6 сая төгрөг болж 10,305.7 сая төгрөгөөр өссөн нь Зам, тээврийн яамнаас авах гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийн авлага 12,216.0 сая төгрөгөөр, байгууллагын дотоод тооцооны авлага 6,803.8 сая төгрөгөөр, татварын авлага 670.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн;
- Бараа материал дансны үлдэгдэл 8,970.1 сая төгрөг болж 3,194.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 25,948.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч 22,753.9 сая төгрөгийн материалыг зарцуулсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 23,400.8 сая төгрөг болж 2,689.0 сая төгрөгөөр буурсан нь 4,560.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсан нь голлох нөлөө үзүүлсэн ба

933.7 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, ТӨБЗГ-ын 2025 оны 133, 377, 682 дугаар тогтоолуудаар 406.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 402.7 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 14.0 сая төгрөгийн компьютер, нийт 823.2 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч бүртгэсэн;

- Биет бус хөрөнгийн дансанд 20 салбар, нэгтгэлийн төвд ашиглаж байгаа 1,629.9 сая төгрөгийн Санхүүгийн тооцоолох компанийн FISCUS санхүүгийн программ хангамж, 4,724.8 сая төгрөгийн 62 газар эзэмших эрх бүртгэлтэй байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 25,738.9 сая төгрөг болж 12,480.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн нэгжид өгөх өглөг 10,735.5 сая төгрөгөөр, татварын өглөг 3,018.3 сая төгрөгөөр, ажилчид, хувь хүнд өгөх өглөг 1,583.1 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөө үзүүлсэн;
- Засгийн газрын хувь оролцооны дүн 26,971.2 сая төгрөг болж 265.6 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоолоор Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны урт хугацааны зээлийн санхүүжилтээр зам засвар, арчлалтын компаниудад хэрэгжүүлсэн тээвэр хөгжүүлэх төслийн үр дүнд бий болсон хөрөнгийн хэмжээгээр эдгээр компаниудын дүрмийн санг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу урт хугацаат зээлийн дансанд бүртгэлтэй байсан 3,417.2 сая төгрөгийн зээлийг хааж, дүрмийн санг нэмэгдүүлсэн, салбаруудын үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллын зөрүү 1,616.7 сая төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулгаар бүртгэсэн, тайлант онд 1,534.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан зэрэгтэй тус тус холбоотой байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

#### **3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК нь эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2024 оны 723 дугаар тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталжээ. Тайлант оны нийт орлогыг 76,219.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 75,887.2 сая төгрөгөөр, 332.4 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 8,602.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

#### **3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 54,483.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 55,985.5 сая төгрөгийн зардал гарган, 1,534.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 54,483.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 21,736.3 сая төгрөг буюу 28.5 хувиар тасарсан байна. Энэ нь Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын улсын төсвийн санхүүжилтийг багасган баталсан, уг төсөвтэй уялдуулан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтод түвшний төлөвлөгөөг тодотгон батлуулаагүйтэй холбоотой байна. Тухайлбал: Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын 2025 оны төлөвлөгөөг Зам тээврийн сайдын 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн А/63 дугаар тушаалаар 57,566.6 сая төгрөгөөр баталж, Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн А/217 дугаар тушаалаар 42,585.4 сая төгрөг болгон тус тус шинэчлэн баталсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 55,985.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 19,901.6 сая төгрөг буюу 26.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь гүйцэтгэх ажлын тоо хэмжээ буурсантай холбоотой байна. Өмнөх онтой харьцуулахад орлого 6.1 хувиар, зардал 8.6 хувиар тус тус буурснаас харахад зардлын бууралт 2.5 хувиар илүү байгаа нь зардал хэмнэгдсэн гэж үзэхээр байна.

Их засвар, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд өөрийн эх үүсвэрээс 1,008.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 1,534.8 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, өмнөх оноос 1,680.9 сая төгрөг буюу 52.3 хувиар алдагдлыг бууруулсан, төлөвлөснөөс 1,867.3 сая төгрөгөөр дутуу байгаа нь гүйцэтгэх ажлын тоо хэмжээний бууралтай холбоотой байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- ТУЗ-ийн 2025 оны 25/07 дугаар тогтоолоор Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн орон тооны дээд хязгаарыг үндсэн орон тоог 799, гэрээт гүүр хамгаалагч 66 байхаар тогтоож, зохион байгуулалтын бүтцийг 3 хэлтэс, 20 салбартай байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 729 ажилтан ажиллаж 70 ажилтны орон тоо дутуу ажилласан байна. Цалингийн зардалд 25,455.2 сая төгрөг төлөвлөснөөс 21,246.6 сая төгрөг зарцуулж 4,208.6 сая төгрөг дутуу зарцуулсан байна.
- Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК нь тайлант онд байгууллагын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэгийг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, ажлын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж ажилтнуудыг сургалтад үе шаттайгаар хамруулан ажилласан байна. Тайлант онд сургалтын зардалд 171.3 сая төгрөг батлагдсанаас 36.9 сая төгрөг зарцуулсан байна.
- Гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Б/114 тоот тушаалаар ажлын нэг өдөрт хоолонд 6.0 мянган төгрөг, унаанд 3.0 мянган төгрөгийн хөнгөлөлт олгохоор баталсан байна. Тайлант онд нийт 382.9 сая төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт ажилчдад олгосон байна.
- Тайлант онд гадаад томилолт, арга хэмжээ, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний төлбөр, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардлууд гараагүй байна.

### **3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК нь тайлант онд нийт 40,903.6 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, компанийн ТУЗ-ийн 2025 оны 25/03 тоот тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Нээлттэй тендер шалгаруулалтаар 37,170.7 сая төгрөгийн 34, харьцуулалтын аргаар 2,558.3 сая төгрөгийн 37, шууд худалдан авалтаар 1,174.5 сая төгрөгийн 91 бараа ажил үйлчилгээг тус тус худалдан авахаар төлөвлөсөн байна.

Батлагдсан төлөвлөгөөнөөс 10,896.7 сая төгрөгийн худалдан авалтын эрхийг салбаруудын гүйцэтгэх удирдлагуудад шилжүүлж 30,033.9 сая төгрөгийн худалдан авалтыг АЗЗА Нэгтгэлд зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтаар 19,650.7 сая төгрөгийн 16, харьцуулалтын аргаар 1,634.4 сая төгрөгийн 24, шууд худалдан авалтаар 675.2 сая төгрөгийн 55, нийт 21,960.3 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг тус тус худалдан авсан байна.

Батлагдсан төлөвлөгөөнөөс ажлын тоо хэмжээ хасагдсанаас шалтгаалан тухай худалдан авалтыг хийх шаардлагагүй болсон, тендер зарласан боловч оролцогчгүй зэрэг шалтгаанаар нийт 15,543.7 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд АЗЗАН ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөх, худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулах, нэгдсэн төвийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх асуудлыг зохицуулсан журам боловсруулан мөрдөх, салбарын бүртгэлд тавих хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аккаунт траст ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа, захирал П.Наранцэцэг нар, дараагийн шатны хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Мөнхбилгүүн, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

АЗЗАН ТӨХК 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 65 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 63,794.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 637.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн 50 болон түүнээс дээш хувийн оролцоотой хуулийн этгээдүүдэд хамаарах зохицуулалтыг мөрдөх шаардлагатай бөгөөд уг хуулийн 3.1.4-т зааснаар төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлага, албан тушаалтнууд хуулийн үйлчлэх хүрээнд багтдаг.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 76 заалтаас шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай 43 заалтын хэрэгжилтэд аудитын горим, сорил гүйцэтгэсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажилласнаар өмнөх онтой харьцуулахад зардлыг 2.5 хувиар бууруулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 3,738,2 сая төгрөгийн зөрчилд 2,147.2 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1,591.0 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,358.7 сая төгрөгийн 72 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

Мөн Баянчандмань, Булган, Налайх, Орхон салбарт нийт 232.2 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй зөрчил илэрсэнд 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Илрүүлэлт 1: Шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлаагүй 2,147.2 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг 26 аж ахуйн нэгжээс шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 31 дүгээр зүйлийн 31.1-д “Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:” 31.1.1-д “нээлттэй;”, 31.1.2-т “харьцуулалт;”, 31.1.3-т “гэрээ шууд байгуулах;”, 31.1.4-т “нэг эх үүсвэрээс худалдан авах.”, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг, Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа, ажил үйлчилгээ-100.0 сая, ажил 150.0” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давсан бараа ажил үйлчилгээг шууд худалдан авдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа нь

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, илрүүлсэн 43,082.4 сая төгрөгийн 7 алдааг залруулах саналыг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Аудитаар илэрсэн алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-нд 95.9 сая зөрчилд 1 албан шаардлага, 159.2 сая төгрөгийн 6 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	1	95,888.6	1	95,888.6	100.0
2	Зөвлөмж	6	159,171.0	6	159,171.0	100.0
	<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>255,059.6</b>	<b>7</b>	<b>255,059.6</b>	<b>100.0</b>

Өмнөх аудитаар 20 салбарт 28.3 сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт, 3,111.9 сая төгрөгийн зөрчилд 23 албан шаардлага, 2,551.0 сая төгрөгийн зөрчилд 46 зөвлөмж өгснийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Салбаруудын төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д/Д	Нэр	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт		Бие лэлт
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Архангай	1	3,063.6	4	757,553.6	-	-	5	760,617.2	100.0
2	Багануур	-	-	-	-	5	56,125.0	5	56,125.0	100.0
3	Баянчандмань	-	-	1	934,944.9	2	72,281.8	3	1,007,226.7	100.0
4	Булган	4	11,812.5	-	-	2	160,270.0	6	172,082.5	100.0
5	Говь-Алтай	-	-	6	13,148.5	2	-	8	13,148.5	100.0
6	Дархан	2	2,807.0	2	24,233.9	6	495,789.7	10	522,830.6	100.0
7	Дорноговь	-	-	-	-	1	-	1	-	100.0
8	Завхан	-	-	-	-	-	-	-	-	-
9	Налайх	3	2,837.3	2	578,495.5	5	198,700.0	10	780,032.8	100.0
10	Орхон	4	3,011.9	4	112,987.0	3	-	11	115,998.9	100.0
11	Өвөрхангай									-
12	Сэлэнгэ	-	-	-	-	2	800.0	2	800.0	100.0
13	Талын зам			2	319,600.0	6	932,800.0	8	1,252,400.0	100.0
14	Төв	1	4,750.0	-	-	2	25,120.5	3	29,870.5	100.0

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

15	Увс	-	-	1	2,100.0			1	2,100.0	100.0
16	Хархорин									-
17	Ховд	-	-	-	-	5	577,095.6	5	577,095.6	100.0
18	Хөвсгөл	-	-	1	368,812.1	4	32,008.2	5	400,820.3	100.0
19	Хэнтий									-
20	Эрдэнэсант	-	-	-	-	1	-	1	-	100.0
	Дүн	15	28,282.3	23	3,111,875.5	46	2,550,990.8	84	5,691,148.6	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахуун нийлүүлэх АЗЗАН ТӨХК /20250102057 дугаартай гэрээний дагуу тайлант онд нийт 4,435.1 сая төгрөгийн шатахуун худалдан авсан бөгөөд гэрээний 1.3.6-д заасны дагуу худалдан авалтын дүнгээс 6 хувийн хөнгөлөлт 266.1 сая төгрөгийг тооцон орлого авахаар тооцоо гарсан. Нэгдсэн аргачлалаар хангаагүйгээс салбар бүр харилцан адилгүй бичилт хийсэн байна. Тиймээс дараагийн аудитаар 6 хувийн хөнгөлөлтийн тооцоог нарийвчлан үзэхээр шийдвэрлэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 296.5 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад бүрэн залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Төрийн банкны хуулгаар гарсан 20.0 сая төгрөгийн, капитрон банкны хуулгаар гарсан 151.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг журналд тусгаагүй орхигдуулсан;
- Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн 0.2 сая төгрөг, тендерийн орлогын 1.5 сая төгрөг, даатгалын төлбөрийн буцаалтын 0.4 сая төгрөг, орон нутгийн зам арчлалтын орлогын 0.5 сая төгрөг, нийт 2.7 сая төгрөгийг хүүгийн орлогоор тайлагнасан;
- Нэгтгэлийн төвийн бусад зардалд салбаруудын бараа материал худалдан авалтын 68.2 сая төгрөг, салбарын үйл ажиллагааны санхүүжилтийн 10.0 сая төгрөг, машин техник хэрэгслийн түрээс 9.2 сая төгрөг, сургалтын зардал 2.5 сая төгрөг, томилолтын зардал 1.5 сая төгрөг, нийт 91.5 сая төгрөгийг бүртгэсэн;
- Салбаруудад худалдан авсан 18.7 сая төгрөгийн GPS төхөөрөмжийг автомашины даатгалын зардалд бүртгэсэн;
- Хяналт шалгалтын актын төлбөр 0.5 сая төгрөгийг аудитын төлбөрийн зардлаар тайлагнасан;
- Салбарт шилжүүлсэн 10.1 сая төгрөгийн компьютерыг 2.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн үндсэн хөрөнгө хассан гарзаар бүртгэсэн.

Эдгээр алдаа нь НББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцэхгүй, “ангилал”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 33,257.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 32.7 сая төгрөгийн 11 төлбөрийн акт тогтоож, 27,083.7 сая төгрөгийн 22 албан шаардлага хүргүүлж, 6,140.7 сая төгрөгийн 26 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 33,257.1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 32,619.2 сая төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1. Төвийн санхүүгийн тайланд хийсэн аудит

#### 5.1.1 Албан шаардлага

1. Шатахуун, тос, масло нийлүүлэгчийг сонгон шалгаруулах АЗЗАН ТӨХК /20250102057 дугаартай тендерийн үнэлгээний хорооны хурлаар Шунхлайтрейдинг ХХК, Шунхлай ХХК-уудын түншлэлийг шалгаруулж нийт 6,399.8 сая төгрөгөөр гэрээ байгуулах зөвлөмжийг гүйцэтгэх захиралд хүргүүлсэн байна. Гэтэл гэрээний дүнг үнэлгээний хорооны зөвлөмжөөс 408.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж гэрээг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид “худалдан авах гэрээ” гэх/-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ирүүлсэн тендер байна.”, 39.2-т “Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно.” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Машин механизмын сэлбэг хэрэгсэл, материал худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтад шалгарсан 6 аж ахуйн нэгжээс гэрээний үнийн дүнгийн 20.0 хувиас илүү 137.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3-т “нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;”, 40 дүгээр зүйлийн 40.2-д “Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно:”, 40.2.1-д “энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлээсэн нь: Хууль зөрчин гэрээний дүнгээс илүү худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны орлогын төлөвлөгөө 21,736.3 сая төгрөгөөр тасарсан, Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын төсөвтэй уялдуулан 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний төлөвлөгөөг тодотгон батлуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасантай нийцэхгүй, ТӨБЗГ-ын 2024 оны 723 тоот тогтоолоор тус ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогыг 76,219.6 сая төгрөгөөр баталсанд хүрэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

4. Нийт салбаруудын авлагын дансанд бүртгэлтэй 2-оос дээш жилийн насжилттай 65 харилцагчийн 1,736. сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай авлагын 60-аас дээш хувийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

5. Нийт салбаруудын өглөгийн дансанд бүртгэлтэй 2-оос дээш жилийн насжилттай 53 харилцагчийн 1,179.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олон жилийн насжилттай өглөгийн 60-аас дээш хувийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

### **5.1.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Менежментийн зардлын санхүүжилттэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Авто замын засвар арчлалтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх асуудлыг зохицуулсан журам байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 10-т “эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах;” Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13-т “төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Менежментийн зардлын санхүүжилтийн асуудлыг зохицуулсан журмыг боловсруулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, мөрдөн ажиллах.

#### **2. Нягтлан бодох бүртгэл зохион байгуулалт, хяналттай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Авто замын засвар арчлалтын нэгтгэл болон салбаруудын хоорондын ажил гүйлгээ, салбарын тайланг хэрхэн нэгтгэх зэргийг тусгасан санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллах Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, дансны нэгдсэн төлөвлөгөөгүй, нэг ижил гүйлгээг өөр өөр дансанд бүртгэсэн, салбарын үйл ажиллагааны зардлын санхүүжилт болон худалдан авсан бараа ажил үйлчилгээний төлбөрийг нийлүүлэн зардалд бүртгэсэн нь хөрөнгө мөнгөний зарцуулалт, бэлтгэн нийлүүлэгчдийн тооцоонд хяналт тавихад хүндрэлтэй, төвөөс салбар руу бичсэн ажил гүйлгээний дүн нь салбарын тайлангийн дүнгээс 317.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.”, 20 дугаар зүйлийн 20.2.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг оновчтой зохион байгуулж, нэгтгэлийн үйл ажиллагааны онцлогт тохируулан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах, дотоод хяналтыг сайжруулах.

### **3. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:Татварын цахим системд тайлант онд худалдан авсан 57 харилцагчийн 428.3 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний и баримт бүртгэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.2-т “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлж, татварын цахим системд и баримт шивэгдсэн эсэхэд хяналт хэрэгжүүлэх.

#### **5.2 Харьяа салбаруудад хийсэн аудит**

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны оны санхүүгийн тайланд орон нутаг дахь харьяа 20 салбар байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 16 салбарыг аудитын түүвэрт хамруулсан. Аудитад хамрагдсан Говь-Алтай, Өвөрхангай, Хархорин салбаруудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, Дархан салбарын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Салбаруудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 7,911.6 сая төгрөгийн алдаа зөрчлөөс нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 606.4 сая төгрөгийн 7 алдааг залруулга хийлгэж, 32.7 сая төгрөгийн зөрчилд төсөвт төвлөрүүлэх 11 төлбөрийн акт тогтоож, 1,886.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 17 албан шаардлага хүргүүлж, 5,394.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 23 зөвлөмжийг өгсөн.

##### **5.2.1 Төлбөрийн акт**

Орон нутаг дахь салбаруудад нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж зөрчсөн дараах 32.7 сая төгрөгийн зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Булган салбар нь 0.8 сая төгрөгийн шатахуун, 0.6 сая төгрөгийн хүнсний материал дутагдуулсан;
2. Орхон салбар өмнөх оны санхүүгийн тайлан гаргах бэлтгэл ажлын хүрээнд 5 ажилтанд анхан шатны бүрдэл дутуу баримтаар 4.3 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон;
3. Орхон салбар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актын хүчинтэй хугацаа дууссан ажилтнуудад 0.8 сая төгрөгийн цалин илүү тооцож олгосон;

4. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар Орхон салбар 0.5 сая төгрөгийн, Төв салбар 2.5 сая төгрөгийн томилолтын зардал, Эрдэнэсант салбар 1.6 сая төгрөгийн автомашины оношлогооны төлбөр, 0.1 сая төгрөгийн шатахуун олгосон;
5. Сэлэнгэ салбар нь 5.2 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа, 0.4 сая төгрөгийн хоолны тооцоог тус тус дутуу суутгасан;
6. Хэнтий салбар нь төрийн өмчийн хөрөнгийн түрээс 18.4 сая төгрөгийн орлогын 40 хувь 7.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй.
7. Эрдэнэсант салбарын дарга нь өөрийн хөрөнгийг барьцаалан ББСБ-с 60.0 сая төгрөгийн зээл авч, нягтлан бодогчтой гэрээ хийж байгууллагын данс руу шилжүүлж 54.0 сая төгрөгийг ажилчдын цалинд олгосон, уг зээлийг эргэн төлөхдөө хүү, алдангийн төлбөрийг нийлүүлэн 62.6 сая төгрөгийг төсвөөс төлж 8.6 сая төгрөгийг илүү төлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тогтоосон төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн.

### 5.2.2 Албан шаардлага

Орон нутаг дахь салбаруудад хийсэн аудитаар илэрсэн 1,886.5 сая төгрөгийн зөрчилд 17 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Татварын шалгалтаар Багануур салбарт 55.6 сая төгрөгийн, Налайх салбарт 350.5 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулалт, акт тогтоогдож байгуулагад хохирол учирсан;
2. Баянчандмань салбар 49.4 сая төгрөгийн, Сэлэнгэ салбар 0.2 сая төгрөгийн томилолт , 1,3 сая төгрөгийн цалинг, Эрдэнэсант салбар 39.9 сая төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны дэмжих баримтгүй олгосон;
3. Налайх салбар 38.7 сая төгрөгийн борлуулалтын орлогыг аккруэл сууриар бүртгээгүй;
4. Налайх салбар өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайланг төрийн аудитад хуулийн хугацаанд ирүүлээгүй;
5. Орхон салбар 678.4 сая төгрөгийн, Сэлэнгэ салбар 65.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
6. Орхон салбар 373.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
7. Орхон салбар нь улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй 2 иргэнтэй зээлийн гэрээ байгуулан 70.0 сая төгрөг зээлж , зээлийн хүүгийн төлбөрт сарын 8 хувийн хүү 11.7 сая төгрөг төлсөн;
8. Увс салбар бэлэг худалдан авахад 4.0 сая төгрөг, тээврийн хэрэгслийн торгууль төлөхөд 1.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
9. АЗЗАН ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 25/06 төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор 4 дүгээр сарын 11 ний өдрөөс компани салбар компани болгон зохион байгуулагдаж, Төв АЗЗА ТӨХК-ийн захирлын тушаалаар 2025 оны 4 дүгээр сарын 11-нээс чөлөөлж, мөн өдрөөс Төв АЗЗА ТӨХК төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор салбарын менежерийг гүйцэтгэх захирлын тушаалаар нягтлан бодогчийг, салбарын менежерийн тушаалаар бусад албан хаагч, ажилчдыг томилсон байна. Гэтэл компанийн нэр өөрчлөгдөж салбар компани болсон, АЗЗАН ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэргүй 169.4 сая төгрөгийн цалин олгосон байна.
10. Эрдэнэсант салбар шатахуун зарцуулахдаа жолоочийн замын хуудасгүй шаардах хуудсаар нийт 26.9 сая төгрөгийн шатахуун олгосон;
11. Эрдэнэсант салбар ТӨБЗГ-ын шийдвэргүй 30.0 сая төгрөгийн зээл авснаас, 20.0 сая төгрөгийг төлөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих 5,394.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг шийдвэрлэхээр давтан гаргахгүй байх 23 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Багануур салбар 2.4 сая төгрөгийн, Налайх салбар 14.3 сая төгрөгийн ажил гүйлгээг, дараа тайлангийн дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн;
2. Багануур салбар Автомашины торгуулийн шалтгааныг харгалзахгүйгээр, зохих шийдвэргүйгээр 0.07 сая төгрөг төлж зардалд бүртгэсэн;
3. Багануур салбар, Налайх салбар Эдийн засгийн зорилтот түвшнийг бодитой төлөвлөж батлуулаагүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, алдагдалтай ажилласан;
4. Багануур салбар санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хуульд заасан хугацаанд ирүүлээгүй;
5. Баянчандмань салбар нь эдийн засгийн агуулга, ашиглалтын шинж чанарын хувьд машин, тоног төхөөрөмжийн ангилалд хамаарах 9.2 сая төгрөгийн хөрөнгийг бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн;
6. Баянчандмань салбар нь 2 иргэнээс 39.5 сая төгрөгийн зээл авч буцаан төлсөн;
7. Баянчандмань салбар 1.1 сая төгрөгийг, Эрдэнэсант салбар 2.3 сая төгрөгийг Төв салбар 2.3 сая төгрөгийг хүүхдийн баярын бэлгэнд, Хөвсгөл салбар 2.2 сая төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан;
8. Дорноговь салбарын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн 162 нэр төрлийн 888.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй;
9. Завхан салбар 24.1 сая төгрөгийн, Увс салбар 24.2 сая төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар томилолтын зардал олгосон;
10. Налайх салбарын өөрийн 27.1 мянган төгрөгийн борлуулалтад НӨАТ тооцоогүй нь татварын торгууль, алданги тавигдах эрсдэл үүсгэсэн;
11. Налайх салбар тайлант оны түрээсийн гэрээний жилийн эцэст төлөгдөөгүй 0.5 сая төгрөгийг орлого, авлагаар бүртгээгүй;
12. Орхон салбар ахмадуудад олгосон тэтгэмжийг 1 ахмад настны дансанд нийт дүнгээр нь 278.0 сая төгрөг шилжүүлсэн;
13. Орхон салбар Хувьсах цалинг ажлын үр дүн, гүйцэтгэлд үндэслэн олгоогүй;
14. Төв салбар 5 аж ахуй нэгж байгууллагаас 2,333.0 сая төгрөг, татварын 206.4 сая төгрөгийн нийт 2,559.4 сая төгрөгийн авлагатай;
15. Төв салбар НДШ-ийн 109.8 сая төгрөг ХХОАТ-ын өглөг 64.4 сая төгрөг, цалингийн өглөг 4.4 сая төгрөг, ААНОАТ-ын өглөг 30.2 сая төгрөг, 16 ААН-д 1,430.5 сая төгрөг нийт 1,639.3 сая төгрөгийн өглөгтэй;
16. Увс салбар И баримтаар баталгаажаагүй 14.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн;
17. Ховд салбар 754.6 сая төгрөгийн санхүүжилтийн авлага үүссэнтэй холбоотойгоор авлага, өр төлбөр өссөн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
								Үүнээс					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Төрийн банкны хуулгаар гарсан 20.0 сая төгрөгийн, капитрон банкны хуулгаар гарсан 151.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг журналд тусгаагүй орхигдуулсан;	1	171,094.0	1	171,094.00			1	171,094.0	-	-	-	-
2	Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн 0.2 сая төгрөг, тендерийн орлогын 1.5 сая төгрөг, даатгалын төлбөрийн буцаалтын 0.4 сая төгрөг, орон нутгийн зам арчлалтын орлогын 0.5 сая төгрөг, нийт 2.7 сая төгрөгийг хүүгийн орлогоор тайлагнасан;	1	2,679.7	-	-	1	2,679.7	1	2,679.7	-	-	-	-
3	Нэгтгэлийн төвийн бусад зардалд салбаруудын бараа материал худалдан авалтын 68.2 сая төгрөг, салбарын үйл ажиллагааны санхүүжилтийн 10.0 сая төгрөг, машин техник хэрэгслийн түрээс 9.2 сая төгрөг, сургалтын зардал 2.5 сая төгрөг, томилолтын зардал 1.5 сая төгрөг, нийт 91.5 сая төгрөгийг бүртгэсэн;	1	91,496.3	-	-	1	91,496.3	1	91,496.3	-	-	-	-
4	Салбаруудад худалдан авсан 18.7 сая төгрөгийн GPS төхөөрөмжийг автомашины даатгалын зардалд бүртгэсэн;	1	18,659.4	-	-	1	18,659.4	1	18,659.4	-	-	-	-

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

5	Хяналт шалгалтын актын төлбөр 0.5 сая төгрөгийг аудитын төлбөрийн зардлаар тайлагнасан;	1	500.0	-	-	1	500.0	1	500.0	-	-	-	-
6	Салбарт шилжүүлсэн 10.1 сая төгрөгийн компьютерыг 2.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн үндсэн хөрөнгө хассан гарзаар бүртгэсэн.	1	12,086.0	-	-	1	12,086.0	1	12,086.0	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>6</b>	<b>296,515.4</b>	<b>1</b>	<b>171,094.0</b>	<b>5</b>	<b>125,421.4</b>	<b>6</b>	<b>296,515.4</b>	-	-	-	-

**6.1.2.Салбарын санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган	1	33,000.0			1	33,000.0	1	33,000.0	-	-	-	-
2	Завхан	4	553,966.2			4	553,966.2	4	553,966.2				
3	Төв	2	19,462.0			2	19,462.0	2	19,462.0				
	<b>Дүн</b>	<b>7</b>	<b>606,428.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>7</b>	<b>606,428.2</b>	<b>7</b>	<b>606,428.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

## 6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

### 6.2.1. Нэгтгэлийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	АЗЗАНэгдсэн төвийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх асуудлыг зохицуулсан журам байхгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
2	Төвөөс салбаруудын нягтлан бодох бүртгэлийг нэгдсэн бодлогоор удирдан зохион байгуулж чадаагүй, дансны нэгдсэн төлөвлөгөөгүй, нэг ижил гүйлгээг өөр өөр дансанд бүртгэсэн, салбарын үйл ажиллагааны зардлын санхүүжилт болон худалдан авсан бараа ажил үйлчилгээний төлбөрийг нийлүүлэн зардалд бүртгэсэн нь хөрөнгө мөнгөний зарцуулалт, бэлтгэн нийлүүлэгчдийн тооцоонд хяналт тавихад хүндрэлтэй, төвөөс салбар руу бичсэн ажил гүйлгээний дүн нь салбарын тайлангийн дүнгээс 317.8 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	1	317,787.0	-	-	-	-	1	317,787.0	-	-	-	-
3	"Шатахуун, тос, масло нийлүүлэгчийг сонгон шалгаруулах" АЗЗАНТӨХК/20250102057 дугаартай тендерийн үнэлгээний хорооны хурлаар Шунхлайтрейдинг ХХК, Шунхлай ХХК-уудын түншлэлийг шалгаруулж нийт 6,399.8 сая төгрөгөөр гэрээ байгуулах зөвлөмжийг гүйцэтгэх захиралд хүргүүлсэн байна. Гэтэл гэрээний дүнг үнэлгээний хорооны зөвлөмжөөс 408.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж гэрээг байгуулсан байна.	1	408,500.5	-	-	1	408,500.5	-	-	-	-	-	-
4	Татварын цахим системд тайлант онд худалдан авсан 57 харилцагчийн 428.3 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний и баримт бүртгэгдээгүй байна.	1	428,297.2	-	-	-	-	1	428,297.2	-	-	-	-
5	Нээлтэй тендер шалгаруулалтаар шалгарсан 6 аж ахуйн нэгжээс гэрээний үнийн дүнгийн 20.0 хувиас илүү 137.3 сая төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.	1	137,268.9	-	-	1	137,268.9	-	-	-	-	-	-

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

6	Тайлант оны орлогын төлөвлөгөө 21,736.3 сая төгрөгөөр тасарсан, Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын төсөвтэй уялдуулан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтод түвшний төлөвлөгөөг тодотгон батлуулаагүй байна.	1	21,736,297.6	-	-	1	21,736,297.6	-	-	-	-	-	-
7	Нийт салбаруудын авлагын дансанд бүртгэлтэй 2-оос дээш жилийн насжилттай 65 харилцагчаас авах 1,736.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	1	1,735,989.1	-	-	1	1,735,989.1	-	-	-	-	-	-
8	Нийт салбаруудын өглөгийн дансанд бүртгэлтэй 2-оос дээш жилийн насжилттай 53 харилцагчид өгөх 1,179.2 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна	1	1,179,172.5	-	-	1	1,179,172.5	-	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>8</b>	<b>25,943,312.8</b>	-	-	<b>5</b>	<b>25,197,228.6</b>	<b>3</b>	<b>746,084.2</b>	-	-	-	-
	<b>Салбар</b>	51	7,313,813.9	11	32,738.1	17	1,886,503.2	23	5,394,572.7				
	<b>Нийт дүн</b>	<b>59</b>	<b>33,257,126.7</b>	<b>11</b>	<b>32,738.1</b>	<b>22</b>	<b>27,083,731.8</b>	<b>26</b>	<b>6,140,656.9</b>	-	-	-	-

Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

**6.2.2 Харьяа салбаруудын санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/ Мянган төгрөгөөр/

д/д	Салбарын нэр	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай	-	-	-	-	-	-	-	-
2	Багануур	-	-	1	55,546.2	5	2,454.0	6	58,000.2
3	Баянчандмань	-	-	1	49,428.0	3	49,756.0	4	99,184.0
4	Булган	1	1,335.3	-	-	-	-	1	1,335.3
5	Дорноговь	-	-	1	-	1	-	2	-
6	Завхан	-	-	-	-	1	24,081.1	1	24,081.1
7	Налайх	-	-	3	389,187.1	4	41,895.3	7	431,082.4
8	Орхон	3	5,588.2	4	1,063,716.8	1	278,051.2	8	1,347,356.2
9	Сэлэнгэ	2	5,587.4	2	66,896.9			4	72,484.3
10	Талын зам	-	-	-	-	-	-	-	-
11	Төв	1	2,477.5	1	169,427.6	3	4,200,971.9	5	4,372,877.0
12	Увс	-	-	1	5,459.7	2	38,266.6	3	43,726.3
13	Ховд	-	-	-	-	1	754,600.0	1	754,600.0
14	Хөвсгөл	-	-	-	-	1	2,200.0	1	2,200.0
15	Хэнтий	1	7,334.5	-	-	-	-	1	7,334.5
16	Эрдэнэсант	3	10,415.2	3	86,840.9	1	2,296.6	7	99,552.7
	<b>Дүн</b>	<b>11</b>	<b>32,738.1</b>	<b>17</b>	<b>1,886,503.2</b>	<b>23</b>	<b>5,394,572.7</b>	<b>51</b>	<b>7,313,813.9</b>

### 6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

#### 6.3.1 Нэгтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,358.7 сая төгрөгийн 72 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	1,358,746	-	-	-	-	1	1,358,745.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
2	Шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан 2,147.2 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг 26 аж ахуйн нэгжээс шууд худалдан авсан байна.	1	2,147,188.5	-	-	1	2,147,188.5	-	-
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,505,934.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>2,147,188.5</b>	<b>1</b>	<b>1,358,745.6</b>

**6.3.2 Харьяа салбаруудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/ Мянган төгрөгөөр/

д/д	Салбарын нэр	Нийт дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянчандмань	1	-		-	1	-	-	-
2	Булган	1	125,791.2	-	-	-	-	1	125,791.2
3	Налайх	1	106,500.9	-	-	-	-	1	106,500.9
4	Орхон	1	-	-	-	-	-	1	-
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>232,292.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>232,292.1</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 895/А0150053

Улаанбаатар хот

САГ - 2026/2/НА-СТА-ТӨАГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахуун, тос, масло нийлүүлэгчийг сонгон шалгаруулах АЗЗАНТӨХК/20250102057 дугаартай тендерийн үнэлгээний хорооны хурлаар Шунхлай трейдинг ХХК, Шунхлай ХХК-уудын түншлэлийг шалгаруулж нийт 6,399,840,540.00/ зургаан тэрбум гурван зуун ерэн есөн сая найман зуун дөчин мянга таван зуун дөчин төгрөгөөр гэрээ байгуулах зөвлөмжийг гүйцэтгэх захиралд хүргүүлсэн байна. Гэтэл гэрээний дүнг үнэлгээний хорооны зөвлөмжөөс 408,500,460.00 /Дөрвөн зуун найман сая таван зуун мянга дөрвөн зуун жаран/ төгрөгөөр нэмэгдүүлж гэрээг байгуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д "Захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид "худалдан авах гэрээ" гэх/-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна.", 39.2-т "Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол," гэж заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал /Б.Наранбат/, ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Оргил/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
П.НАРАНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 896/AD150053

Улаанбаатар хот

САГ-2026/2/НА-СТА-ТВАГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Машин механизмын сэлбэг хэрэгсэл, бараа материал нийлүүлэгчийг сонгох нээлттэй тендерт шалгарсан 6 аж ахуйн нэгжээс гэрээний үнийн дүнгийн 20.0 хувиас илүү 137,268,866.00 /Нэг зуун гучин долоон сая хоёр зуун жаран найман мянга найман зуун жаран зургаан/ төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3-т "нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;" 40 дүгээр зүйлийн 40.2-д "Худалдан авах гэрээ болон ерөнхий гэрээний үүргийн гүйцэтгэлийн явцад дараах зүйлийг хориглоно:" 40.2.1-д "энэ хуулийн 40.1-д зааснаас бусад үндэслэлээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах;" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

ИймТөрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;" гэж заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Хууль зөрчин гэрээний дүнгээс илүү худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Наранбат/, ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Оргил/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
П.НАРАНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баян тойруу-3. Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-26-230

9005109  
АТН16037  
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-67.Docx

1526191198



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 897/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/2/НА -СТА -ТВАГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан 2,147,188,503.00 /Хоёр тэрбум нэг зуун дөчин долоон сая нэг зуун наян найман мянга таван зуун гурван/ төгрөгийн бараа ажил үйлчилгээг 26 аж ахуйн нэгжээс шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:" 31.1.1-д "нээлттэй"; 31.1.2-т "харьцуулалт"; 31.1.3-т "гэрээ шууд байгуулах"; 31.1.4-т "нэг эх үүсвэрээс худалдан авах", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг, Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа, ажил үйлчилгээ-100.0 сая, ажил 150.0" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давсан бараа ажил үйлчилгээг шууд худалдан авдаг зөрчлийг таслан зогсоох, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Наранбат/, ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Оргил/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
П.НАРАНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 898/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/2/НА -СТА-ТӨАГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт салбаруудын авлагын дансанд бүртгэлтэй 2-оос дээш жилийн насжилттай 65 харилцагчийн 1,735,989,140.00 /нэг тэрбум долоон зуун гучин таван сая есөн зуун наян есөн мянга нэг зуун дөчин/ төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11.хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Олон жилийн насжилтай авлагын 60-аас дээш хувийг барагдуулж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Наранбат/, ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Оргил/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
П.НАРАНЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 899/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/2/КА-СТА-ТВАГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт салбаруудын өглөгийн дансанд бүртгэлтэй 2-оос дээш жилийн насжилттай 53 харилцагчийн 1,179,172,549.00 /Нэг тэрбум нэг зуун далан есөн сая нэг зуун далан хоёр мянга таван зуун дөчин есөн/ төгрөгийн өглөгийг барагдуулаагүй байна

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11.хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Олон жилийн насжилттай өглөгийн 60-аас дээш хувийг барагдуулж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Наранбат/, ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Оргил/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮДЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
П.НАРАНЦЭЦЭГ

9006109  
ATA16087  
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 900/АД/50053

Улаанбаатар хот

САГ-2026/2/НА-СТА-ТӨАГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны орлогын төлөвлөгөө 21,736,297,623.00 /Хорин нэгэн тэрбум долоон зуун гучин зургаан сая хоёр зуун ерэн долоон мянга зургаан зуун хорин гурван/ төгрөгөөр тасарсан, Улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын төсөвтэй уялдуулан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтод түвшний төлөвлөгөөг тодотгон батлуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай нийцэхгүй, ТӨБЗГ-ын 2024 оны 723 тоот тогтоолоор тус ТӨХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин орлогыг 76,219.6 сая төгрөгөөр баталсанд хүрэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Наранбат/, ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Оргил/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
П.НАРАНЦЭЦЭГ

9006109  
ATA16007  
9025081411

ТӨСӨЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z. Alban Shaardlaga 2026.0316.SAG-67.Docx

1526181200